

МОНГОЛ, ЭНЭТХЭГИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫН
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Н.Ариунзаяа*

* БНЭУ-ын Шинэ Дели хотын Олон нийтийн харилцааны дээд сургуулийн сонсогч, сэтгүүл зүйн доктор (Ph.D.)

Түлхүүр үг: өргөн нэвтрүүлэг, олон нийтийн харилцаа, сорилт, өрсөлдөөн, супер компьютер, программ хангамж, мэдээллийн технологи

Энэ төсөрхөн өгүүллийг эдүгээгээс зуун жилийн өмнө алдарт Марк Твений хэлсэн нэгэн үгээр эхлэхийг хүслээ. Тэрбээр «Энэтхэг бол мөрөөдөл, гайхамшигт эд баялаг, үгээгүй хоосон, сүр жавхлан, гэрэл гялбаа, сүрлэг ордон, урц овоохой, аварга бирд, Аладдины дэнлүү, бар, заан, кобра могой, ширэнгэ ойн газар нутаг юм. Энэ бол зуу зуун хэлээр ярьдаг зуу зуун үндэстэн, мянган шашин, хоёр буман бурхдын орон юм. Энэ бол хүн төрөлхтний өлгий, хүний хэл ярианы төрсөн нутаг, түүхийн эх, үлгэр домгийн өлгий юм. Энэ бол харь нутгийн хан хүү, харц ядуу тариачин, эрдэм мэдлэгтэн, харанхуй бүдүүлгүүд, ухаант мэргэд, унхиагүй тэнэг, баячууд, ядуус, эрх чөлөөтөн, эрх чөлөөгүй хөөрхийс бүгдэд танин мэдэх агуу хүсэл төрүүлдэг цорын ганц орон билээ» гэсэн байдаг. Энэ үгнээс Энэтхэг орны гайхамшигтай, бас гаслантай дүр зургийг төсөөлж болно. Харин өнөөдрийн Энэтхэг орны дүр зураг өөр юм.

Юуны өмнө Энэтхэг улс бичиг үсэг, ном хэвлэлийн арвин уламжлалтай Азийн эртний соёлт орнуудын нэг юм. Тэрхүү соёлын суурин дээр орчин үеийн утга зохиол, сэтгүүл зүй цэцэглэн хөгжиж, ялангуяа мэдээллийн технологийн салбарт томоохон хувьсгал хийж, тэргүүлэх зэрэгт хүрсэн байна.

Энэтхэгийн сэтгүүлч бэлтгэдэг дагнасан том төв нь Шинэ Дели хотын Олон нийтийн харилцааны дээд сургууль юм. Энэ сургуулийн эх суурь анх 1867 онд тэр үед мөрдөгдөж байсан «Нийгэмлэгүүдийн бүртгэлийн хууль»-ийн дагуу албан ёсоор байгуулагдаж, эрдэм шинжилгээний нийгэмлэгийн хэлбэрээр ажиллаж эхэлсэн байна. Түүнээс 100 шахам жилийн дараа буюу 1965 оны 8-р сарын 17-нд тухайн үед Энэтхэгийн мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн яамны сайд байсан Индира Гандигийн санаачилгаар ЮНЕСКО-гийн хоёр зөвлөх мэргэжилтэн бүхий цөөн орон тоотой Олон нийтийн харилцааны дээд сургууль болж үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлсэн ажээ. Тэр цагаас хойш сургуулийн стратегийг Ерөнхий захирал, факультетуудын декан, багш нар, мэдээллийн байгууллагын нэр хүндтэй төлөөлөгчдөөс бүрдсэн Удирдах зөвлөл боловсруулж, өдөр тутмын үйл

ажиллагааг Захирлуудын зөвлөл зохицуулж ирсэн байна.

Тус дээд сургууль нийгмийн хөгжилд шаардлагатай харилцааны олон төрлийг харгалзан үзэж танхимын, дадлагын, судалгааны гэсэн үндсэн хэлбэрүүдээр сургалт явуулж, сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны мэргэжилтэн бэлтгэдэг бөгөөд, төгсөгчид нь дэлхийн мэдээлэл харилцааны өрсөлдөөний сорилтыг даван туулж чадахуйц өндөр түвшинд бэлтгэгддэг байна.

Одоогоос арван жилийн өмнө тус сургууль хүрээгээ дахин тэлж, үндсэн сургалтаас гадна хөгжиж буй орнуудын сэтгүүл зүйд ажиллах мэргэжилтэн бэлтгэх олон шатлалтай сургалтыг эхлүүлсэн байна. Сургалтын хөтөлбөрүүд нь түргэн хурдацтай өсч байгаа хэвлэл мэдээллийн болон олон нийтийн харилцааны салбарын ажиллах хүчний шаардлагыг хангахад чиглэн төрөлжсөний зэрэгцээ, болзошгүй өөрчлөлтүүдэд бэлэн байхын тулд жил бүр өөрчилж болохуйц байдлаар зохицуулагдсан байдаг. Өөрөөр хэлбэл мэргэжлийн хүрээнд үүссэн нөхцөл байдлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор хөдөлгөөнтэй, уян хатан сургалт явуулдаг гэсэн үг.

Тус сургууль түүхэн хөгжлийн явцад бүтээсэн боловсрол, сургалт, судалгааны ажлын амжилтаараа бахархах хэмжээнд хүрсэн байна. Үүнийг жил бүр өсөн нэмэгдэж байгаа элсэн суралцагчдын тоон үзүүлэлт нэн тодорхой харуулдаг. Энэтхэгийн олон нийтийн харилцааны дээд сургууль нэгэнт Ази, Африк, Латин Америкийн хөгжиж буй орнуудын сэтгүүлч, олон нийтийн харилцааны мэргэжилтнүүдийг бэлтгэдэг төв болж чадсан юм. Эдүгээ тус сургуулийн мэргэжил дээшлүүлэх хийгээд магистр, докторын сургалтад Орос, Чили, Армени, Колумби, Ливан,

Узбекистан, Бангладеш, Зимбабве, Нигери, Мали, Конго, Замби, Мавритани, Уганда, Сьерра-Леоне, Намиби, Мьянма, Монгол, Танзани, Ливан, Этиоп зэрэг тавь шахам орны оюутан, сонсогчид хамрагдаж байна.

Тус сургууль 1969 оноос хөгжиж буй орнуудын сэтгүүлчдийг магистр, докторын сургалтанд хамруулах зорилготой Олон улсын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ үеэс Ази, Африкийн сэтгүүлчид өргөн хамрагдах болжээ. Дараагийн шатанд төрийн болон олон нийтийн байгууллагад ажиллаж байгаа харилцааны ажилтнуудын мэргэжлийг ахиулах зорилгоор долоо хоногоос гурван сарын хугацаатай сургалт явуулж эхэлсэн бол эдүгээ сэтгүүлч, олон нийтийн харилцааны шаталсан сургалтыг олон төрөл, мэргэшлээр явуулах болжээ. Сургалтын чанар сайжирч, сургуулийн нэр хүнд өсөхийн хэрээр олон салбар, мэргэшлийн сургалтыг шинээр нээх шаардлагатай тулгарч эхэлсэн байна.

Энэ шаардлагын дагуу 1993 оноос Зүүн бүсийнхний хэрэгцээг хангах зорилгоор тус сургуулийн хоёр салбарыг Денканал, Орисса хотуудад, Хойт бүсийн Амравати, Айзволд хотуудад мөн хоёр салбарыг нээсэн бол, энэ хичээлийн жилээс Керелагийн Коттоямд дахин хоёр салбар нээж, тэдгээрт зөвхөн англи хэлээр аспирантурын сургалт явуулж эхэлсэн байна.

Ер нь Энэтхэгийн олон нийтийн харилцааны дээд сургуулийн мэргэжил дээшлүүлэх болон магистр, докторын сургалтанд хамрагдахын тулд лекц ойлгох хэмжээний англи хэлтэй байхыг шаарддаг. Бүс нутгийн сэтгүүлчдэд зориулсан сургалтууд нь англи, энэтхэг, ория зэрэг хэлээр явагддаг.

Тус сургуулийн нэг онцлог бол орчин үеийн мэдээлэл харилцааны салбарт сонирхол татах болсон олон нийтийн харилцааны онол, арга зүйг хөгжүүлэх, энэ чиглэлийн мэргэжилтнүүдийн тоог олшруулж, чанарыг сайжруулахад онцгой анхаардаг явдал мөн. Тиймээс ч сургалтад нь олон нийтийн харилцааны онол, дадлага зонхилох байр суурь эзэлдэг бөгөөд энэ нь суралцагсдын сонирхолд нийцдэг байна. Энэтхэг улс мэдээллийн технологийн хөгжлөөрөө Ази, Номхон далайн бүс нутгийг араасаа дагуулж, ялангуяа компьютерийн программ хангамжаар дэлхийд тэргүүлдэг орон юм. Сүүлийн үед компьютерийн гол гол компаниуд болон үндэстэн дамнасан корпора-

циуд тус улсыг өөрийн программ хангамжийн төв болгохыг эрмэлзэх болжээ. Учир нь зах зээл сайтай, ажиллах хүч хямд, түүнчлэн энэ чиглэлийн мэргэшсэн ажилтан олонтой.

Сүүлийн үеийн баримтаар "Фортуна" сэтгүүлийн нэрлэсэн 500 компанийн 130 гаруй нь Энэтхэгийг өөрсдийн программ хангамжийн төв болгоод байгаа аж. Тус улс бас параллель супер компьютерийн салбарт хүч сорьж өөрийн орны шинжлэх ухаан, технологийн байгууллагуудад энэ чиглэлийн бүхэл бүтэн тогтолцоо буй болгож¹ чадсан байна. Пуне дахь дэвшилтэт компьютерийн төвд зохион бүтээсэн хамгийн сүүлийн үеийн «ПАРАМ-9000» супер компьютерээ Вашингтонд дэлгэн үзүүлснээр энэ салбарын хөгжлөөр АНУ, ХБНГУ-ын

дараа орох хэмжээнд хүрчээ. Ийнхүү тус оронд эрч хүчээ авч байгаа орчин үеийн мэдээллийн технологийн хувьсгалын ололтууд сэтгүүл зүйн сургалтын уламжлалт арга хэлбэрийг өөрчилж, бүтэц, агуулгыг эргэн харах шаардлагыг зүй ёсоор төрүүлж байгаа билээ.

Дээр дурдсан хувьсгал бас олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэргэжилтэн, сэтгүүл зүйн багш, оюутнуудын өмнө шинэ, том сорилтыг авчирсан юм. Өөрөөр хэлбэл техник технологийн

дэвшил нь академик сургалтаас бусад салбарын сургалтыг олон хувилбартайгаар өөрчлөхийг шаардаж байгаа юм. Энэ шаардлагыг тус сургуулийн бодлого тодорхойлогчид гярхай мэдэрч, цаг үеийн шаардлагад нийцсэн сургалт

«

Тус сургуулийн нэг онцлог бол орчин үеийн мэдээлэл харилцааны салбарт сонирхол татах болсон олон нийтийн харилцааны онол, арга зүйг хөгжүүлэх, энэ чиглэлийн мэргэжилтнүүдийн тоог олшруулж, чанарыг сайжруулахад онцгой анхаардаг явдал мөн.

»

явуулдгаараа нэрд гарчээ.

Энэтхэгийн сэтгүүл зүйн сургалтын томоохон онцлогийн нэг нь сургалтын арга барилыг мэдээллийн технологийн дэвшилтэй уялдуулан боловсруулдаг явдал мөн. Энэ орны сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд үзэг, цаас хоёрыг музейд тавих хэмжээнд аль хэдийнээ хүрсэн байна. Тус сургуулийн сургалт орчин үеийн сэтгүүл зүйн практикт өргөн нэвтэрч байгаа ICT (information and communication technologies), MIL (Media and information literacy), SMS (Short-messaging system) зэрэгтэй нягт уялдаатай явагддаг. Ялангуяа өнөөгийн сэтгүүлчдэд өндөр хурдтай, бүтээмж сайтай ажиллах боломж олгодог ICT-ийн дэвшлийг ашиглах аргыг зааж сурахад онцгой анхаардаг байна. Internet, mobile-

phone, Google, Facebook, Twitter гэх мэт дэвшилт арга технологиуд оюутан, суралцагчдын үйл ажиллагааны хэм хэмжээ болоод удсан юм. Сургуулиас багш оюутан, олон нийттэй харилцах үйл явц хийгээд сургалтын удирдлага, зохион байгуулалт, түүнчлэн багш, оюутны харилцан мэдээлэл солилцох, оюутны сурлагын чанарыг үнэлж дүгнэх зэрэг бүхий л үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжжээ. Өөрөөр хэлбэл биеэр уулзаж, цаасаар харилцдаг аргаас бүрэн салсан байна. Гэтэл энэ чиглэлийн ажил манай төрийн өмчит томоохон их, дээд сургуулиудад дөнгөж эхлэлийн төдий байгаа билээ. Дээд боловсролын системд олонх болж байгаа хувийн их, дээд сургуулиудын хувьд энэ тухай ярихын ч хэрэггүй. Тэд ажилтай, ажилгүй арав хорин компьютертэй "лаборатори" гэгчээ үзлэг шалгалтынхны амыг хаах хэрэгсэл болгохоос цааш хэтрэхгүй байна. МУИС-ийн хэмжээнд SIS1 программыг нэвтрүүлж байгаа нь шинэ эхлэл боловч сургалтын бүх харилцааг зохицуулах хэмжээнд хүрээгүй байна. Наад зах нь оюутны сурлагын дүнг цаг тухайд нь хянаж бүртгэх, оюутны ирцийг тэмдэглэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг цахим сүлжээнд оруулах ажил ор нэрийн төдий хийгдэж байгааг дурдахад хангалттай.

Энэтхэгийн сэтгүүл зүйн сургалтын өөр нэг томоохон ололт нь сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, техник хэрэгслийг өргөн ашигладаг явдал мөн. Оюутан, магистрант, докторантууд мэргэжлийн түвшинд тоноглогдсон теле, радио студид дадлага хийж, сургуулиас эрхлэн гаргадаг сонин, сэтгүүлийг гардан хариуцаж ажилладаг. «Телевиз болон дүрс бичлэгийн студи гэхэд л доод зах нь 12 камертай бөгөөд нэг зэрэг зургаан

камер ажиллах боломжтойн дээр, тогтмол цагийн цахилгаан үүсгүүрт удирдах пульт, эвлүүлгийн самбар, гэрэлтүүлгийн хөнгөн төхөөрөмж, дижитал дуу эвлүүлэг, шугаман бус дүрс эвлүүлэгч зэрэг төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг. Дүрс эвлүүлгийн төхөөрөмж нь серверт суурилсан сүлжээ болох Авид-аас гадна, хасалт хийх мэргэжлийн машинтай. Тус сургуулийн Фото лаборатори нь зураг авах өндөр хүч чадалтай олон аппаратын зэрэгцээ оюутнууд ямарч даалгавар хийж, хэвлэлийн эх бэлтгэхэд хүрэлцэхүйц техник хэрэгслээр тоноглогдсон байдаг. Мөн кино зургийн болон слайдны аппарат, LCD төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд тэр нь график дизайн болоод торгон дэлгэцэт хэвлэл хийхэд хангалттай хүрэлцдэг. Олон нийтийн харилцааны салбар, ялангуяа компьютерийн техникт үндэслэсэн редакторлах, хэвлэн нийтлэх ажлын хөгжилтэй хөл нийлүүлэхийн тулд тус сургууль компьютер, мультимедиа систем, электрон эвлүүлэг, компьютерт суурилсан график дизайны сургалт явуулдаг»² байна.

Мөн олон нийтийн мэдээллийн салбаруудын программ хангамжийн технологиудыг сайн эзэмшүүлэхийн тулд Майкрософт оффис, Адоб пэйжмэйкер, Куарк Экспресс, Адоб фотошоп, Корел дроу, Макромедиа дайректор зэрэг программуудыг оюутанд заавал эзэмшүүлдэг. Ингэхийн тулд компьютерийн мэдлэг муутай оюутнуудыг хичээлийн жилийн эхэнд тусгай курст хамруулж түвшинг ойртуулдаг юм. Сургуулийн хотхон бүхэлдээ ВайПай сүлжээнд холбогдсон байдаг нь бас нэг давуу тал болдог. Оюутнууд хичээлээс гадуур гүйцэтгэх даалгавар, илтгэл, өгүүлэл, ангийн ажил зэргийг манайхан шиг гараар бичиж, сайндаа л

компьютерт алдаа мадагтай шивж тооцуулдаггүй, сургуулийн болон нийтийн хэвлэл мэдээлэлд гаргаж байж үнэлгээгээ авдаг. Багшийн заагуур, шохой хоёр эдүгээ нэгэнт домог болжээ. Энэ нь сургалтад техник хэрэгслийг өргөн нэвтрүүлсний үр дүн юм. Багш, гартаа байгаа удирдлагын товчлуурыг дарах төдийд хүссэн мэдлэг мэдээллүүд томъёо тодорхойлолт, загвар бүдүүвч, зураг хөрөгтэйгөө дэлгэцэнд хөврөн гарч ирнэ. Хүсвэл оюутанд файлаар өгч ч болно. Танхимын хичээлийг заавал ямар нэг техник хэрэгсэл ашиглаж, эсвэл биет үзүүлэн дээр тайлбарлаж, өөрсдөөр нь үйлдүүлж, хийлгэх аргаар заана. Гэтэл бидний сургалтын материаллаг бааз ямар түвшинд байгаа билээ!

Энэтхэгийн их, дээд сургуулийн багш нарын сургалтын арга барил, технологи ихээхэн өөрчлөгдсөн байна. Багш мэдлэг, мэдээллийг бэлнээр нь цутгагч биш, харин мэдлэг эзэмших үйл явцыг чиглүүлэгч, хянагч болж хувирсан байна. Оюутны сурах хөдөлмөрийн гуравны хоёрыг хичээлээс гадуур хийх даалгавар, сорил, туршилт, бүтээлч ажил эзэлдэг. «Бэлэн мэдлэг өгөх нь оюутныг идэвхгүй, сул дорой, сэтгэх чадваргүй болгодог, харин мэдлэг рүү чиглүүлж удирдах нь тэднийг бие даасан үйл ажиллагаанд сургаж, шинийг сэдэх, бүтээж туурвих урам зоригтой болгодог»³ гэж үздэг байна. Өөр нэг анзаарагдсан зүйл бол профессор багш нарын ачаалал бага байдаг юм байна. Энэ нь нэг талаар танхимын хичээл харьцангуй бага байдагтай, нөгөө талаар багшийг хөгжүүлж, эрдэм шинжилгээний ажил хийх бололцоогоор хангах зорилготой холбоотой аж. Манай улсын их, дээд сургуулийн профессор нэг хичээлийн жилд танхимд 12 кредит цагийн хичээл

зааж, 10 кредит цагийн эрдэм шинжилгээний ажил хийх ёстой байдаг. Гэтэл Энэтхэгт эрдмийн өндөр зэрэгтэй профессоруудын танхимын хичээлийн норм манайхаас хэд дахин бага байдгийн дээр, ийм зэрэглэлийн багш бакалаврын түвшинд бараг ордоггүй, харин магистр, докторын сургалтанд гол хүч болж ажилладаг. Харин багш нарын зэрэг дэв өгсөх тутам ачаалал хөнгөрдөг, шинэ залуу багш нарын танхимд биелүүлэх кредит цаг өндөр байдаг зэргээрээ манайтай адил юм.

Энэтхэгийн сэтгүүл зүйн сургалтын нэг онцлог нь мэргэжлийн гол хичээлүүдийг зэрэгцүүлэн үздэггүй, суурь ойлголтуудаас нь эхлэн дараалуулж үздэг явдал юм. Бас нэг онцлог нь манай сургуулиуд шиг хоёр хичээлийн жилийн завсарт үйлдвэрлэлийн дадлагыг ерөнхийлж, бөөнөөр нь хийдэггүй, хичээл бүрийг үзэж дууссаны дараа тухайн хичээлийн дадлагыг хийж хамгаалсны эцэст дараагийн хичээлийг үздэг. Жишээ нь радиогийн, сонины, телевизийн, олон нийтийн харилцааны гэх мэтээр дадлагыг төрөлжүүлэн харьцангуй богино хугацаатай хийдэг.

Манай улсад сэтгүүл зүйн бакалаврын сургалтын стандарт тогтоогдож, түүнийг дагалдсан технологийн баримт бичгүүдийг боловсруулж мөрдөөд арав шахам жил болж байна. Гэтэл Энэтхэгт дээд боловсролтой сэтгүүлч бэлтгэх шаталсан сургалтын иж бүрэн стандарт хөтөлбөрийг мөрдөөд удаж байгаа аж. Өөрөөр хэлбэл магистр, докторын сургалтын түвшин, үйлч шинжийг тодорхойлсон стандартыг сургалтанд аль хэдийнээ хэрэгжүүлж иржээ. Шаталсан сургалтын зааг ялгаа, онол практикийн түвшин их тодорхой байдаг юм байна. Магистр, докторын сургалтыг төрөлжүүлсэн байдлаар явуулдаг

нь сэтгүүлч, судлаачдыг нарийн мэргэшүүлэхэд хэрэгтэй, манайд авч хэрэглүүштэй туршлага юм. Тухайлбал магистр, докторын сургалт нь сэтгүүл зүйн, радиогийн, телевизийн, реклам сурталчилгааны, PR-ийн гэх мэтээр төрөлжсөн бөгөөд жишээ нь телевизийн чиглэлээр суралцаж байгаа хүн зөвхөн тухайн чиглэлийн хичээлүүдийг л гүнзгийрүүлэн судалдаг байх юм. Хоёр, гуравдугаар шатны сургалтын хүрэх үр дүнг нарийн тодорхойлж, түүнд дүйцэхүйц байдлаар сургалтаа явуулдаг аж. Жишээ нь радиогийн чиглэлээр докторын сургалт дүүргэсэн сэтгүүлч ярианы болон визуал бүтээлч харилцаанд өрсөлдөх чадвартай, ёс зүйн мэдлэг эзэмшиж үйл ажиллагааны хэм хэмжээ болгосон, улс төр, зах зээл, технологийн үйл өөрчлөлт хувьслуудад дүгнэлт хийж, хариу үйлчлэл үзүүлж чаддаг, даяар нэвтрүүлэг болон радиогийн технологийн дэвшлийг бүтээх бэлтгэлтэй, радиогийн нэвтрүүлэг, үйлдвэр үйлчилгээний шинэ арга барил, чадварыг хөгжүүлж чаддаг, камертай харьцаж, дүрс эвлүүлэх, дуу бичихээс гадна шугаман болон шугаман бус системийн эвлүүлэг хийх чадваруудыг эзэмшиж, эцэст нь энэ бүх чадваруудыг эзэмших онолын үндсийг боловсруулах хэмжээнд бэлтгэгдсэн байх⁴-ыг шаарддаг байна.

Хэрэв PR-ийн чиглэлээр суралцаж байгаа бол харилцаа, маркетинг, зар сурталчилгаа, хамтын ажиллагааны арга барил, зарчмыг бүрэн эзэмшсэн, харилцааны үүрэг, чадамж, зорилгот олон нийтэд нөлөөлөх арга барилд дадлагажсан, байгууллагынхаа стратегийн зорилгод хүрэхийн тулд харилцааны дэвшилт аргуудыг хэрэглэж сурсан, харилцааг шинжлэх ухаан, урлагийн талаас нь ашиглаж сурах чухал нөхцөл болсон техникийн программууд болон

Интернет, мэдээллийн технологийг сайн эзэмшсэн, харилцааг зохион байгуулах, шийдвэр гаргах баг бүрдүүлж, манлайлан удирдах арга барилтай болсон байх чадваруудыг үндсэн зорилго болгодог байна.

Энэтхэгийн Олон нийтийн харилцааны дээд сургуулийн сэтгүүлч болох хүмүүсийг шалгаруулж авах систем сонирхолтой юм. Юуны өмнө улс төрийн өндөр мэдэрэмжтэй, урлан бүтээх авьяас билэгтэй залуусыг шалгаруулж авахад ихээхэн анхаардаг аж. Энэ шалгуурын хүрээнд авах бичгийн шалгалт нь элсэгчийн ерөнхий мэдлэгийн түвшин, нийгмийн динамикийн тухай ойлголт, түүхийн мэдлэг сонирхол, эдийн засаг, улс төрийн сэдвээр мэтгэлцэх чадвар, олон улсын хөгжил болон үйл явдал Энэтхэгт хэрхэн нөлөөлж байгаа талаарх ойлголт, төсөөллийг нь мэдэхэд чиглэдэг байна. Манайх шиг ерөнхий эрдмийн хичээлээр нийтийн жишгийг баримтлан элсүүлдэггүй, шалгалтаа өөрсдөө авдаг. Дотоодын элсэгчдийг аль болох чирэгдэл багатай элсүүлэх зорилгоор газар нутгийн ойролцоо Шинэ Дели, Бубанескар, Колката, Лукнов, Мумбай, Патна, Гувахати, Банглов, Нагпур, Айзвал, Ченнай, Кочи, Жамму, Сринагар, Бхопал зэрэг бүс нутгийн төвүүдэд бичгийн шалгалт авч, тэнцсэн хүмүүстэй ярилцлага хийж шалгаруулдаг юм байна. Хоёр шалгалтын дүнгийн харьцаа 85:15 байх бөгөөд элсэгчдийг сонгосон мэргэшлийн дагуу хувааж, оноогоор нь жагсаагаад хяналтын тоогоор шилж авдаг. Шалгалтыг хинди, англи, ория хэлний аль нэгээр авна.

Оюутны нийгмийн асуудал, сургалтын орчныг сайжруулахад ихээхэн анхаардаг нь бидэнд үлгэр болох юм. Денканал, Амравати, Жамму, Коттояма

зэрэг олонх салбарууд оюутны дотуур байртайн дээр Шинэ Дели, Айзвалд зөвхөн эмэгтэй оюутнуудад зориулсан, бас гэр бүлээрээ суух боломж бүхий оюутны байртай юм. Сургууль өөрийн хөрөнгөөр жил тутам шилдэг долоон оюутанд хагас төлбөртэй тэтгэлэг, нэг эмэгтэй оюутанд Рати Аггарвалын нэрэмжит тэтгэлэг олгодог. Мөн «Стар» телевизийн тэтгэлгийг радио, телевизийн ангийн нэг оюутанд, Ачин Гангулугийн нэрэмжит тэтгэлгийг реклам, сурталчилгааны ангийн нэг оюутанд тус тус олгодог байна. Эдгээрээс гадна амьдралын түвшин доогуур оюутнуудад сурлагын дүнг харгалзан санхүүгийн туслалцаа үзүүлэх механизм ч байдаг аж.

Оюутныг дэмжиж туслахын зэрэгцээ сурах хөдөлмөртөө хариуцлагатай хандах хөшүүргийг ч ашигладаг байна. Тухайлбал оюутан наад зах нь тухайн хичээлийн 75,0 хувьд сууж байж улирлын шалгалт өгөх эрх олж авдаг. Хичээлээс гадуур бие дааж гүйцэтгэх ажлын даалгавар маш их бөгөөд түүнийг биелүүлсэн нөхцөлд шалгалт авна. Дахин өгөх шалгалт бүрд 100 рупи (2500 төгрөг) төлнө. Оюутанд номын сангаар төлбөргүй үйлчлүүлэх эрхийн бичиг олгох бөгөөд долоо хоногт хоёроос цөөнгүй номыг гадуур авч болдог. Жилийн туршид номын сангаар үйлчлүүлээгүй бол эрхийн бичгийг нь хурааж авдаг. Хүндэтгэх шалтгаанаар хичээлийн 10,0 хувьд сууж чадаагүй бол ерөнхий захирал шалтгааныг харгалзан өршөөл үзүүлж, шалгалт өгөх эрх олгох⁵ журамтай.

Энэтхэгийн Олон нийтийн харилцааны дээд сургууль нь өөрийн орны төрийн болон төрийн бус байгууллагуудаас гадна хамтын ажиллагаатай орнууд, олон улсын байгууллагуудад зориулсан сургалт явуулах

арвин туршлага хуримтлуулсан газар юм. Эднийх сэтгүүл зүйн сургалтандаа олон ургальч үзлийг хүндэтгэх, улмаар хязгааргүй дэлхий ертөнцийн эрх чөлөөний дүр төрхийг бүтээх зорилтыг тавьдаг байна. Ингэх нь тулгамдаж байгаа асуудлаар оюутнуудын саналыг солилцуулах, харилцааны арга барил эзэмшиж, мэтгэлцэх чадварыг ахиулах нэг янзын сургалт болдог байна. Энэ зорилгоор оюутнуудын дунд сэтгүүл зүйн үүрэг, агуулга, ёс зүй, социологи гэх мэт олон сэдвээр бага хурал, симпозиум, семинар зохион байгуулж хэвшжээ.

Энэ мэт арга хэмжээний үр дүнг жилд хоёроос цөөнгүй удаа ном болгон хэвлүүлж түгээдэг байна. Тус сургууль сүүлийн дөчин жилд салбарын хамтын ажиллагааг хүчирхэгжүүлэх талаар ихээхэн чармайлт гаргасны үр дүнд сургуулийн нэр хүнд үлэмж өсч, олонх төгсөгч нь гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд манлайлах үүрэгтэй ажиллаж, хоорондоо нягт хамтран ажилладаг бүхэл бүтэн тогтолцоог бүрдүүлж чадсан нь бид бүхний анхаарлыг зүй ёсоор татаж байна. Улсын төв телевиз, радио болон долоо хоног тутмын «Нью эйдж», «Хайат», сар тутмын онолын сэтгүүл «Парти лайф», «Коммунист», түүнчлэн намын «Пиплз демокраси», «Лок лахар» зэрэг нэр хүндтэй мэдээллийн хэрэгслүүдийг хөдөлгөгч гол хүч нь тус сургуулийг төгсөгчид байдаг.

Эцэст нь тэмдэглэхэд Энэтхэгийн сэтгүүлч бэлтгэх, давтан сургах гол төв болсон Олон нийтийн харилцааны дээд сургуулийн бодлого тодорхойлогчид Монголын сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудтай харилцаа тогтоож, хамтын ажиллагаа хөгжүүлэх сонирхолтойн дээр манай орноос оюутан элсүүлэх, ялангуяа магистр, докторын

сургалтанд хамрагдахыг хүссэн хүмүүсийг хүлээн авч сургах сонирхол илүү их байгаагаа илэрхийлэхийн хамт www.iimc.gov.in хаягаар харилцахыг хүсч байгааг уламжилъя.

Ишлэл

- ¹ 2012. Development journalism. New Delhi. №58, p. 71.
- ² 2011. Indian Institute of Mass Communication. New Delhi, p. 14
- ³ 2012. Development journalism. New Delhi. №58, p. 26.
- ⁴ 2012. Development journalism. New Delhi. №58, p. 55.
- ⁵ 2012. Indian Institute of Mass Communication. New Delhi, p. 21.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М., Чойсамба Ч. 2009. Дэлхийн сэтгүүл зүйн түүх. УБ.
2. Норовсүрэн Л., Ариунзаяа Н. Телевизийн сэтгүүл зүй. УБ.

3. Засурский Я. Н. (Ред). 1976. Журналистика в буржуазном обществе. М.

4. 1987. Страны мира. М.

5. Юровский А. 1983. Телевидение: поиски и решения. М.2012.

6. Development Journalism. New Delhi. №58.

7. 2012. Indian Institute of Mass Communication. New Delhi.

Резюме

В настоящей статье автор на основе сопоставительного анализа ВУЗов Монголии и Индии, в которых подготавливаются журналистские кадры, предприняла попытку выявить преимущества последних. Чтобы распространить опыт индийских ВУЗов в данной сфере, автор на примере Института массовых коммуникаций Индии подробно изложила специфику журналистского обучения, его методику и технологию, в частности, опыт, накопленный в области среды обучения, обеспечения материальной базы, использования инновационных достижений в информационных технологиях и т. п.